

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ГАМШГИЙН ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС

Г.Ганхөлөг

ДХИС-ийн “Ахлагч” Мэргэжлийн боловсролын сургуулийн
Онцгой байдлын албаны тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа

E-mail: g.gankhulug427@gmail.com

Хураангуй

Монгол улс болон бүс нутгийн хэмжээнд тэр дундаа Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц гамшгийн тоонд яах ч арга аргагүй уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах хүнчин зүйлсүүд байна. Үүнийг тодорхойлвол “Үерийн гамшиг”, “Агаарын бохирдол”, “Газар хөдлөлтийн гамшиг”, “Ой хээрийн түймэр” гэх зэрэг гамшгийн төрлүүд эрсдэлт нөхцөл байдал үүсгэж байна. Эдгээр гамшгийн төрлүүдийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг үндэсний хэмжээний асуудал болгон ажиллах нь чухал юм. Ард иргэдийг гамшгийн бэлэн байдалд сурган дадлагажуулах, онол практикийн сургалтад хамруулах, үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөнийг тогтмол хийж байх нь бид бүх нийтээрээ гамшгийг сөрөн тэсвэрлэх, түүнээс урьдчилан сэргийлэх хамгийн том гарц гэж үзэж байна.

Түлхүүр үг: Гамшгийн эрсдэл, Гамшиг, Газар хөдлөлт, Агаарын бохирдол, Үер, Ой хээрийн түймэр, урьдчилан сэргийлэх.

Оршил

Үндэсний аюулгүй байдал бол Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард түмний сайн сайхан амьдрал зэрэг улс орны үндсэн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой цогц ойлголт юм. Үндэсний аюулгүй байдалд байгалийн болон нийгмийн янз бүрийн хүчин зүйлс нөлөөлж болох бөгөөд тэдгээрийн нэг нь гамшгийн эрсдэл юм.

Монгол Улс газар зүйн байршил, эх газрын эрс тэс уур амьсгал зэргээс хамааран дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг орнуудын нэг болохыг эрдэмтэн, судлаачид нотлож байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтөд иргэдийн дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрт хариу арга хэмжээ авах чадавхыг инновацы хөгжил, шинэлэг технологийг ашиглан сайжруулах, гамшгаас хамгаалах зорилтод арга хэмжээг шинэчлэх цаг үеийн зайлшгүй шаардлага бий болгож байна.

Гамшгийн эрсдэл: нь байгалийн болон хүний үйл ажиллагаанаас

үүдэлтэй аюулт үзэгдэл тохиолдох магадлал болон түүнээс үүдэн гарах үр дагавар юм. Энэ нь улс орны хүн ам, эд хөрөнгө, байгаль орчинд үлэмж их хэмжээний хохирол учирч болох хохирлыг илэрхийлдэг. Гамшгаас хамгаалах өнөөгийн тогтолцоо бол гамшиг, аюул тохиолдсоны дараа бус уур амьсгал, гамшгийн олон аюулын эрсдэлийг урьдчилан үнэлж, сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах, салбар дундын удирдлагыг хэрэгжүүлэх удирдлагын цогц тогтолцоонд шилжин ажиллаж байна. Энэ хүрээнд “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хүрээ хөтөлбөрийг Монгол Улсад дунд хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г нийт гурван үе шаттайгаар 2017-2030 хүртэл “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”, “Алсын хараа-2050” зэрэг стратегийн бодлого хөтөлбөртэй нийцүүлэн ажиллаж байна. Дээрх стратегийн хүрээнд бид хот суурин газарт өсөн нэмэгдэж буй хүн амд гамшгийн зарлан мэдээллийг хүргэх, иргэнээс эхлээд аж ахуйн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын бүх түвшинд эрсдэлийг бодитой үнэлж, төлөвлөлт бэлэн байдлыг хангуулах, үндэсний хэмжээнд гамшгийг тэсвэрлэх чадавхыг бий болгох зорилтыг тэргүүлэх чиглэлээ болгох шаардлагатай байна.

Сүүлийн 50 жилд цаг агаар, уур амьсгал, устай холбоотой аюулт үзэгдлээс шалтгаалсан 12.000 орчим гамшиг дохиолдож, хоёр сая гаруй хүн ам амь насаа алдаж, дэлхийн эдийн засагт 3.6 их наяд долларын бодит хохирол учруулсан тоон мэдээллийг олон улсын байгууллагууд гаргаж байна. Жишээлбэл: 2022 он буюу 2 жилийн өмнө “Дэлхийн гамшгийн эрсдэлийн тайлан”-д уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан гамшиг, аюулт үзэгдлийн тоо дараагийн таван жилд 30-40 хувь нэмэгдхийг тэмдэглэж анхааруулсан. Уламулалт нүүдлийн аж ахуйд суурилсан Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан ган, зуд, хүчтэй салхи шуурганы давтамж, үер ус, ой хээрийн түймэр, газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл улам бүр харилцан хамааралтай болж байгаа бөгөөд хавсарсан эрсдэлүүд үүсэж хариу арга хэмжээ авах цаг хугацаа улам бүр богиносож, Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг мэргэжлийн байж богино цаг хугацаанд иргэдэд хүртээмжтэй хүрч ажиллахыг шаардаж байгаа нь өргөн уудам нутагтай, хот суурин газартаа хүн амын төвлөрөл ихтэй манай орны хувьд томоохон сорилтыг бий болгож байна.

Гамшиг, аюулт үзэгдлээс иргэдийн амь нас эд хөрөнгийг авран хамгаалах тэргүүлэх чиг үүргээс гадна гамшгийн үед дулаан, эрчим хүч, зам гүүр зэрэг нэн чухал дэд бүтцийн аюулгүй байдлыг хангуулах, иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд салбар дундын удирдлага

зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлага бидэнд тулгарч байна. Сүүлийн жилүүдэд хот суурин газруудад гэнэтийн аадар бороо, үерийн улмаас хүний амь нас, эд хөрөнгөд учрах хохирол нэмэгдэж байгаа нь онцгой байдлын байгууллагад тулгарч буй бас нэгэн сорилт гэж үзэж байна. Уур амьсгалаас үүдэлтэй гамшгийн эрсдэлийн тоо, давтамж ийнхүү нэмэгдэж, олон төрлийн “шинэ” эрсдэл үүсэж байгаагаас шалтгаалан онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг мэргэжлийн түвшинд сургаж бэлтгэх, орчин цагийн шинэ технологи, багаж хэрэгсэлтэй ажиллах чадавхыг эзэмшүүлж, аврах, гал унтраах тоног төхөөрөмж, техник зэвсэглэмжийн хангалт, хөдөлмөр хамгааллыг шинэчлэх шаардлагатай байна.

Энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд төр, засгаас ихэд анхаарч, зөвхөн улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас гадна гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар техник тоног төхөөрөмжийн хангалтыг хийж ирсэн. Одоогийн байдлаар техник, тоног төхөөрөмжийн хангалт 57 хувь, алба хаагчдын тусгай зориулалтын хувцас хэрэглэл 37-40 хувийн хангамжтай байгаа бол хамгийн дутагдалтай нь гамшгийн үед үүрэг гүйцэтгэх харилцаа холбооны бэлэн байдал, иргэдэд хүргэх зарлан мэдээллийн систем 26-28 хувьтай байгаа юм.

Үүнтэй зэрэгцээд иргэдийн дунд гамшиг гэдэг ойлголтыг ухуулан сурталчиллуулах бүх нийтээр гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлаа хангахад нөлөөлийн арга хэмжээг зохион байгуулах нь чухал. Иргэдийг гамшигтай тэмцэх, гамшгийн дараах хор хохирол хэрхэн үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх тухай сурган дадлагажуулах нэн шаардлага үүсч байна. Мөн хот төлөвлөлтийн замбараагүй байдалыг халж хотыг тэлэх, зарим нэг ойролцоо аймагт дагуул хотуудын зохион байгуулалтад оруулах нь зүйтэй.

Хот суурин газрын төвлөрөл нь манай орны хувьд тэр дундаа “Газар хөдлөлт”-н гамшгийн хамгийн өндөр эрсдэлтэй бүс нутагт оршин байгаа нь газар хөдлөлтийн гамшгийн хөнөөл учруулах хохиролын хэмжээг хэрхэн нөлөөлөхийг төсөөлж бараашгүй. Тиймээс гамшигт тэсвэртэй хот болгохын тулд иргэн бүрийн гамшгийн тухай ойлголт, гамшигтай тэмцэх, гамшгийн бэлтгэл бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах чадварт сурган дадлагажуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна. Мөн гамшиг хэнийг ч ялгадаггүйн тод жишээг дэлхийн улс орнуудад болж буй гамшиг, гамшгийн хор хохирлын хэмжээнээс харж болно.

Гамшгийн үеийн шуурхай үйл ажиллагаа бол талуудын оролцоог бүхэлд нь хамарсан үйл ажиллагаа учир төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, ард иргэдэд үүрэг хариуцлагыг нь бүрэн ойлгуулах, эрсдэлийн боловсрол мэдлэгийг олгох, тэднийг сургаж дадлагажуулах нь бидний тэргүүлэх чиглэл юм. Энэ хүрээнд Засгийн газар “Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлан 2025 он хүртэл хэрэгжүүлж, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах ухамсарт соёл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг Онцгой байдлын байгууллага тавин ажиллаж байна.

Сүүлийн 20 жилд гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдол 30.2 хувиар, гамшиг ослын улмаас амь насаа алдсан хүний тоо 9.9 хувиар, бэртэж гэмтсэн хүний тоо 10.3 хувиар, улс орны эдийн засагт учирсан хохирол 54.8 хувиар өссөн. Гамшиг, аюулт үзэгдлээс шалтгаалж эдийн засгийн тогтвортой хөгжил, иргэдийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөлөл улам бүр өссөн үзүүлэлт статистик тоон мэдээл гарч байна.

Монгол орны эрсдэлийн зураглал хот, хөдөөгөөр харилцан адилгүй. Тухайлбал, хот суурин газарт орон сууцны болон ахуйн гал түймрийн эрсдэл өндөр, барилга орон сууц, дэд бүтцийн хувьд хур борооны үер, газар хөдлөлтийг тэсвэрлэх чадавх хангалтгүй. Нийслэлийн хэмжээнд олон аюулд хамгийн их өртөж буй нь Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг. Үерийн аюулд өртөх бүсчлэлд хотын хүн амын 40 хувь амьдарч, 5.5-аас дээш магнитудын газар хөдлөлтөд 97 хувь нь өртөх өндөр эрсдэлтэй. Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд иргэд нэн тэргүүнд эрсдэлийн хүчин зүйлийг ойлгож, үнэлэх хэрэгтэй. Тухайлбал, амьдарч буй газар оронд гамшгийн ямар эрсдэл байгааг сайтар ойлгох нь эрсдэлийг бууруулж, урьдчилан сэргийлэх боломжийг бий болгодог. Нийслэлийн иргэд гамшиг, аюулт үзэгдлийн сэрэмжлүүлэг мэдээнд сонор соргог байж, өрх бүр гамшгийн зарлан мэдээллийг хүлээн авч, хариу арга хэмжээ авах арга дадлыг эзэмших нь тэргүүлэх ач холбогдолтой. Амь нас, эд хөрөнгө, барилга орон сууцыг гал түймэр, газар хөдлөлт, үерийн эсрэг гамшгийн эрсдэлийн даатгалд даатгуулах, өрхийн түвшинд гамшиг ослын үед авах арга хэмжээг төлөвлөж, бэлэн байх юм. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд гамшгийн эрсдэлийг бууруулах хөрөнгө санхүү, гамшгаас хамгаалах зардлыг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэж, эрсдэлийн

удирдлагыг өөрийн салбарын болон орон нутгийн хөгжлийн хөтөлбөр зорилтод тусгаж, гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгож, тасралтгүй туршиж тодотгох, гамшгийн хор уршгийг арилгах удирдлага зохицуулалтын чадавхыг дор бүрнээ ханган ажиллавал гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, хохирлыг бууруулах юм.

Томоохон гамшиг тохиолдоход Онцгой байдлын байгууллагын нөөц хүрэлцэхгүй байх, хүрч очих хугацаа алдах тохиолдол гарна. Энэ үед иргэд бие биедээ туслах сэтгэлтэй, мэдлэгтэй, чадавхтай байхыг аль ч улс оронд зөвлөдөг. Манай улс ч мөн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, сайн дурын бүлэг, иргэдийг бэлтгэж ирсэн.

Ой, хээрийн түймэр гэдэг нь ой, хээрийн бүсэд байгалийн болон хүний үйл ажиллагааны үүдэн шатамхай ургамал хөрсөөр дамжин гал хяналтгүй тархах үзэгдэл юм. Ойн түймэр нь байгалийн үзэгдэл болох аянга цахилгаанаас гарах, хүний хайхрамжгүй байдлаас үүдэн гардаг жишээлбэл: Ил задгай гал түлэх, тамхины иш хаях, санаатайгаар түймэр тавих, мод бэлтгэх үйлдвэрлэлийн технологийн зэрэг үзэгдлээс шалтгаалж байна.

Монгол Улс нь 4 бүсэд хуваагддаг бөгөөд ихэвчлэн хангайн бүс буюу хойд бүс, тал хээрийн бүс буюу зүүн бүсэд ой, хээрийн түймэр гардаг. Тохиолдож байсан томоохон хэмжээний ой хээрийн түймрээс дурьдвал завхан аймагт 1996 онд тохиолдсон ойн түймэрт 120 гаруй хоног 280 гаруй алба хаагч, 2017 оны зүүн 3 аймгийг хамарсан хээрийн түймэрт 30 гаруй хоног 250 гаруй алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэж байсан түүхтэй.

1970-2000 оны хооронд түймрийн эргүүлийн нислэг хийж байсан бөгөөд тухайн үед АН-2 загварын далавчит онгоцоор 10 хүний бүрэлдэхүүнтэй шүхэрчин гал сөнөөгчид нислэг үйлдэж түймрийг агаараас илрүүлэн богино хугацаанд унтрааж байсан сайн туршлагатай байжээ. Мөн ой бүсэд ойн цэвэрлэгээг жил болгон хийж байсан нь түймэр гарах эрсдэлийг бууруулж байсан байна.

Өнөөдрийн нөхцөлд хуурай сэрүүн цаг агаартай манай орны хувьд ой, хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд түргэн шуурхай унтраах хуучны дадлага туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай байгаа юм.

Ялангуяа ой, хээрийн түймрийг хиймэл дагуулын тусламжтай болон нислэг үйлдэж буй агаарын тээврийн компаниудтай нягт хамтран ажиллах шаардлага нөхцөл тулгарч байна. Их хэмжээний түймэр гарсан тохиолдолд мргэжлийн аврагч-гал сөнөөгчдийг тухайн түймэр гарсан орон нутагт тээвэрлэн хүргэхэд хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх

шаардлагатай байна.

Мөн ой, хээрийн түймэр унраах орчин үеийн техник тоног төхөөрөмжүүдийг түймэр унтраах үйл ажиллагаанд түлхүү ашиглах хэрэгцээ шаардлага үүсч байна.

Монгол Улсын сүүлийн 2 жилийн хугацаанд ой, хээрийн түймэр 2022 онд 181 тохиолдол 922,423 га талбай 2023 онд 101 тохиолдол 543,986 га талбай өртөж унтраах үйл ажиллагаанд давхардсан тоогоор Онцгой байдлын байгууллагын аврагч, гал сөнөөгчид мэргэжлийн ангийн болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сайн дурын бүлэгүүд нийт 11,589 албан хаагч ажиллсан байна.

Дээрхээс үзхэд ой хээрийн түймэр нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мөн хүний буруутай үйл ажиллагаа зэргээс гарч байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, иргэн аж ахуй нэгж байгууллагыг дадлгажуулах ажлыг тус тус хийвэл зохистой.

Гамшгийн эрсдэлт хүчин зүйлс

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг жагсааж үзвэл. Үүнд:

БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛ

Газар хөдлөлтийн гамшиг

Монгол Улс Евразийн хавтангийн заагт оршдог тул газар хөдлөлтийн идэвхтэй бүсүүдтэй. Улаанбаатар хот болон орон нутагт томоохон хэмжээний газар хөдлөлт болох маш өндөр эрсдэлтэй.

Цаг агаарын өөрчлөлт ган, зудын гамшиг

Хүйтэн сэрүүн уур амьсгалтай тул өвлийн улиралд зуд тохиолдох эрсдэл ихтэй. Энэ нь мал аж ахуй, хөдөө ахуйн салбарт ихээхэн хохирол учруулдаг.

Хэт халалт, гангийн улмаас ургамалын гарц муудах, усны нөөц хомсдох, ой хээрийн түймэр гарах өндөр эрсдэлтэй.

Үерийн гамшиг

Гол мөрөн, нуурын усны түвшин нэмэгдэх, бороо улиралд түр зуурын хүчтэй аадар бороо орсны улмаас үерийн аюул үүсэх.

Хот суурин газарт ялангуяа Улаанбаатар хотод үерийн ус зайлуулах систем муу хийгдсэн нь нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлж байгаа эрсдэл.

ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Уул уурхайн олборлолт

Байгалийн баялгийн олборлолт, нөхөн сэргээлт муу хийгдэх нь хөрс, ус, агаарын бохирдол үүсгэж хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой

нөлөө үзүүлснээс үүдэх аюул.

Хотжилт, хүн амын төвлөрөл

Улаанбаатар хотод хүн амын хэт төвлөрөл нь дэд бүтцийн ачааллыг нэмэгдүүлж, агаарын бохирдол, усны нөөцийн хомсдол, хог хаягдлын асуудлал ихсэх эрсдэл өндөр.

Агаарын бохирдол

Гэр хорооллын айлуудын нүүрс түлшний хэрэглээ, автомашины утаа зэрэг ныхүний эрүүл мэндэд үлэмж их хэмжээний хортой нөлөөллийг үзүүлэх эрсдэлтэй.

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛ

Халдварт өвчин тархах эрсдэл: Мал, амьтнаас хүнд халдварлах өвчин, хүн амын дунд тархах халдварт өвчин, цар тахал ын эрсдэл.

Ундны ус ариун цэврийн эрсдэл нь хөдөө орон нутаг болон хотын захын дүүргүүдэд ундны ус, орчны бохирдол, ариун цэврийн байгууламжийн хангалтгүй байдал халдварт өвчний эх үүсвэр бий болох эрсдэл.

Эдгээр хүчин зүйлс дээр нэмэгдэж нийгмийн эдийн засгийн эрсдэлт хүчин зүйлс болох ядуурал ажилгүйдэл, дэд бүтцийн сул хөгжил, боловсрол, мэдлэг, дадал бүх нийтийн гамшгийн бэлэн байдлын сургалт дадлага байнга зохион байгуулагдахгүй байгаа асуудлууд нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлж гамшгийн хэмжээнд хүрэх өндөр эрсдэл дагуулж байна.

Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах үндэсний хэмжээний хөтөлбөр, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд хэрэгжиж байна:

- Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр. 2015 онд батлагдсан энэ хөтөлбөр нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилготой.
- Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ (2015-2030). Монгол Улс НҮБ-ын "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ (2015-2030)" баримт бичгийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг боловсруулан, 2021-2025 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ стратеги нь гамшгийн эрсдэлийг ойлгох, удирдах, хөрөнгө оруулалт хийх, бэлэн байдлыг хангах зэрэг чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөсөн.

- Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл нь гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлого, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Тус зөвлөл нь гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулж, холбогдох стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.
- Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлт (Дэд бүтцийн салбар). Гамшгийн эрсдэлийг бууруулахыг хөгжлийн төлөвлөлтөд уялдуулан тусгах зорилгоор үндэсний болон салбарын хөгжлийн бүх төсөл, хөтөлбөрүүдэд болзошгүй гамшгийн эрсдэлийг тон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагаа явагдаж байна. Эдгээр хөтөлбөр, стратеги, төлөвлөгөөнүүд нь Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг багасгах чиглэлээр хэрэгжиж буй голлох үйл ажиллагаанууд юм.

ЭХ СУРВАЛЖ

1. ОБЕГ, “Гамшгийн эрсдэлийн удирдлага” бүх шатны гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, гамшгаас хамгаалах албадын бүрэлдэхүүнд зориулсан гарын авлага, 2023 он, УБ хот
2. Гамшгаас хамгаалах цагаан ном 2024 он
3. Онцгой байдлын ерөнхий газар дэлгэрэнгүй статистик тоон мэдээлэл www.nema.gov.mn
4. Сэлэнгэ аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, 2007 он
 5. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын баримт бичиг 2023 он /эмхэтгэл/
 6. <https://legalinfo.mn>
 7. <https://nema.gov.mn/undesnii-zuwlul>
 8. <https://globalplatform.undrr.org>
 9. <https://globalplatform.undrr.org>